



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 15 сарын 02 өдөр

Дугаар 37

Номгон

“Хүүхдэд ээлтэй орон нутаг” аймгийн
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “ж”, 20 дугаар зүйлийн 20.1.7, Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.5, Аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийн нэгдүгээр бүлгийн 11 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хүүхдэд ээлтэй орон нутаг” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, ажлуудыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулан, үр дүнг тооцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын 02-ны
өдрийн 37 дугаар тогтоолын хавсралт



**“ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ОРОН НУТАГ”
АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**

**НЭГ. ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ,
ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

Хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай байдаг.

Сүүлийн жилүүдэд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хэд хэдэн хууль батлагдан хэрэгжиж эхлээд байна. Тухайлбал: Улсын Их Хурлаас 2015 онд Хүүхэд харах үйлчилгээний тухай, 2016 онд Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг баталсан. Улсын Их Хурлаас 2015 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд хүүхдийн эсрэг гэмт хэргийг нэг бүлэг, 2017 онд шинэчлэн батлагдсан Зөрчлийн тухай хуульд хүүхдийн эрхийн зөрчлийг нэг зүйл болгон, 2016 онд шинэчлэн баталсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах зохицуулалтуудыг тус тус хуульчилсан.

Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 270 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг батласан. Эрх зүйн шинэчлэлийн дүнд хүүхдийг нийгмийн бүх орчинд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдлаас ангид байлгах, тэдний хамгаалагдах эрхийг хуулиар баталгаажуулснаар манай улс хүүхдийн эсрэг хүчирхийллийг бүх орчинд хуулиар хориглосон дэлхийн 49 дэх орон болсон.

Хүүхдийн асуудал нь салбар дундын зохицуулалтыг шаардсан цогц асуудал тул Хүүхдийн эрхийн конвенцийг хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг хангахад салбар бүрийн оролцоо чухал байна.

**ХОЁР. ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ
ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА**

Баянхонгор аймгийн нийт хүн ам 2017 онд 87243 болж өмнөх оноос 2,2 хувиар өссөн бөгөөд нийт хүн амын 35.8 хувь буюу 31.305 нь 0-18 хүртэлх насны хүүхэд

байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсээс хийсэн сүүлийн 5 жилийн судалгааны дүнгээс үзэхэд хараа хяналтгүй, гэр бүл, сургуулийн орчинд үе тэнгийнхий хүчирхийлэлд өртсөн, гэмт хэрэг үйлдэж шүүхээр шийтгүүлсэн, хүүхэд хамгааллын үйлчилгээ авахаар хандсан хохирогч хүүхдийн тоо өссөн, хүүхдээс гарсан саналыг шийдвэртээ тусгасан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Засаг даргын захирамж, хүүхдийн асуудлыг тусгасан нэвтрүүлэг, сонин, сэтгүүлийн гаралтын тоо цөөн, хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны гэмт хэрэг нэмэгдсэн, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 87 хувь, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалт 91.7 хувьтай байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалт ердийн болон тусгай цэцэрлэгт 19.5, ердийн болон тусгай сургуульд хамрагдалт 18.4 хувьтай, хүүхдийг тэгш хамруулан сургах арга зүй, хандлага сул байна. Сургууль, цэцэрлэг, хүүхэд хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, төвийн материаллаг бааз, сургалтын хэрэглэгдэхүүн дутагдалтай, орчин хангалтгүй байсаар байна.

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, өсвөр насны охидын төрөлт тууштай буурахгүй, сүүлийн 4 жилийн байдлаар өсвөр насны хүүхдийн нас баралтын 30.7 хувийг амиа хорлолт эзэлж байсан бол 2017 онд 45.4 хувь болж нэмэгдсэн нь анхаарал татаж байна. Ажилгүйдэл 5.6 буюу улсын дунджаас 3.2 хувиар бага хэдий ч ядуурлын түвшин 32.1 буюу 5.4 хувиар өндөр байна.

Иймд хүүхдийн үндсэн эрхийг хангах, хүүхдийн эрүүл, аюулгүй хөгжих орчин, цэвэр ус, ариун цэврийн байгууламжийг зайлшгүй бий болгох чухал шаардлагууд зүй ёсоор тавигдаж байгаа юм.

Баянхонгор сумын нийт хүн ам 2015 онд 29177, 2016 онд 30304, 2017 онд 30931 болж хүн амын төвлөрөл ихэссэн бөгөөд нийт хүн амын 76.8 хувь нь гэр хороололд амьдарч байна. Аймгийн хүн амын өвчлөлд 2015 оноос эхлэн амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлэх шалтгаан болж, улс, аймгийн дунджаас өндөр үзүүлэлттэй /10 000 хүн амд 1776.9/ аймгийн тоонд орж бүртгэгдэж байгаа амьсгалын замын өвчлөлийн 53.3 хувь нь 0-5 насны хүүхдэд тохиолдож, эндэгдлийн тэргүүлэх шалтгааны нэг болж байна

Нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах явдлыг илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах, хүний болон санхүүгийн нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Дээрх асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор “Хүүхдэд ээлтэй орон нутаг” дэд хөтөлбөрийг боловсрууллаа. Энэхүү дэд хөтөлбөр нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2016-

2020)-т хүүхдийн хөгжил, хамгаалал, эрүүл мэнд, боловсролын талаар дэвшүүлсэн зорилт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 270 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”, Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого, НҮБ-ын Хүүхдийн сангийн “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөр, Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн Хүний хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН БАРИМТЛАХ ЗАРЧИМ ХУГАЦАА

3.1. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим:

3.1.1 Орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн хөгжлийн болон салбарын урт хугацааны бодлогуудыг дэмжих, аймгийн хөгжлийн цогц бодлого, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах

3.1.2 Олон улсын төсөл, хөтөлбөр, нийгмийн зөвшил, салбар дундын түншлэлийг эрхэмлэх

3.1.3 Хүүхдэд ээлтэй үйлчилгээний бүхий л сайн туршлага, санаачлагыг урамшуулан дэмжих

3.1.4 Хугацаа: 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 02

ДӨРӨВ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ХҮРЭХ ҮР ДҮН

4.1. Хөтөлбөрийн зорилго

4.1.1 Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлсэн аймаг болох.

4.2. Хөтөлбөрийн зорилт

4.2.1. Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх.

4.2.2. Хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлнэ.

4.2.3. Хүүхдийг сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлж, бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлнэ.

ТАВ.ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

5.1. Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

5.1.1. Эх, нярай болон 5 хүртэлх насны хүүхдэд нэн шаардлагатай эрүүл мэндийн багц тусламжийн хамралтыг нэмэгдүүлэх.

5.1.2. Хүүхдийн сэргийлж болох өвчин, эндэгдэлд (хатгалгаа, сүрьеэ, суулгалт, осол гэмтэл зэрэг) нөлөөлөх хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг аймаг, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж зонхилон тохиолдох өвчин, эмгэгээс сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах.

5.1.3. Хүүхэд бүрийг бодисын солилцооны эмгэг, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд тогтмол хугацаанд хамруулах.

5.1.4. Хөдөөгийн болон орлого багатай зорилтот өрхийн хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авч, нэн шаардлагатай амин дэмээр хангаж хоол тэжээлийн зөвлөгөө өгөх

5.1.5. Хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сайжруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх.

5.1.6. Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол, хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдал, хувцас, тоглоом, хичээлийн хэрэгсэл, сургалтын тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, худалдаанд тавих хяналтыг иргэдийн оролцоотойгоор зохион байгуулах.

5.1.7. Хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүнсний бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээг сургууль, цэцэрлэгийн орчинд хориглох.

5.1.8. Өсвөр үеийнхэнд зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжиж, эрүүл амьдралын хэв маягыг төлөвшүүлэх.

5.1.9. Нөхөн үржихүйн болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг бэхжүүлэх, өндөр эрсдэл бүхий зорилтот бүлгийнхэнд зориулсан урьдчилан сэргийлэх, хамгаалах цогц үйлчилгээг эрчимжүүлэх.

5.1.10. Ерөнхий боловсролын сургуульд эмч, сэтгэл зүйч ажиллуулж, хүүхэд, өсвөр үеийнхний хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх.

5.1.11. Өсвөр үеийнхний эрүүл мэндийн үзүүлэлтийг гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх.

5.1.12. Хүүхдийг насны онцлог, тусгай хэрэгцээнд нь тохируулан асрах, хүмүүжүүлэх мэдлэг, хандлагыг эцэг, эх, асран хамгаалагч нарт төлөвшүүлэх.

5.1.13. Хүүхдийг ахуйн болон зам тээврийн осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар эцэг, эх, асран хамгаалагч, багш нарын хариуцлагыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлыг өрнүүлж, санамж, сэрэмжлүүлэг түгээх.

5.1.14. Агаарын бохирдлын улмаас хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх.

5.1.15. Төрийн болон төрийн өмчит үйлдвэрийн газар, аж ахуй нэгж байгууллага бүхий л хүрээнд “Хүүхдэд ээлтэй байгууллага” бий болгох хөдөлгөөнийг өрнүүлэх, дэмжих.

5.1.16. Сургууль, цэцэрлэгт агаар шүүгчийн хэрэглээг нэмэгдүүлэх, дулааны алдагдлыг бууруулах асуудлыг аж ахуйн нэгж, иргэдийн оролцоотой шийдвэрлэх.

5.1.17. Гэр хорооллын гудамжийг гэрэлтүүлэх, камержуулах, хүүхдүүдэд зориулсан нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах. Гэр хорооллын замуудыг гарц, тэмдэг тэмдэглэгээтэй болгох.

5.1.18. Сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, бохирын цооногийг стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг төр, иргэд, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор шийдвэрлэх.

5.1.19. Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр сургалтын модуль, үйлчилгээний арга зүй боловсруулж хэрэгжүүлэх.

5.1.20. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийг төрөлжүүлэх мэргэшүүлэх үйл ажиллагааг нь сайжруулах.

5.1.21. Дотуур байрны багшийг нийгмийн ажлын чиглэлээр үе шаттай мэргэшүүлэх, ажлын байрны тодорхойлолтод хүүхдэд нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх талаар тусгах.

5.1.22. Боловсролын байгууллагад мэргэжлийн нийгмийн ажилтан ажиллуулах, мэргэжлийн сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх чиглэлээр мэргэшүүлэх.

5.2. Хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх зорилтын хүрээнд:

5.2.1. Бага насны хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд дэмжих чиглэлээр бий болсон сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, эцэг эхийн чадавхыг нэмэгдүүлэх.

5.2.2. Хүүхдийн хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж болох хүчин зүйлсийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх талаар эцэг, эх, асран хамгаалагч, багш нарын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх.

5.2.3. Хүүхдийг амьдрах ухаан, уламжлалт зан заншил, байгаль орчин эх дэлхийгээ хайрлах, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндлэх, хариуцлагатай, итгэл даах чадвартай болгон төлөвшүүлэн хөгжүүлэх.

5.2.4. Сургуулийн өмнөх насны бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулж, сургуульд бэлтгэх.

5.2.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суурь боловсролд тэгш хамруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх, нийгмийн дэд бүтцийг сайжруулах.

5.2.6. Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд тохирсон сургалтын хөтөлбөр боловсруулах.

5.2.7. Хүүхдийн тоглоомын талбай, чөлөөт цагийн төв байгуулах, тохижуулах, засварлах талаар санаачилга гаргаж байгаа иргэн, байгууллагыг дэмжих, олон нийтэд сурталчлах.

5.2.8. Хичээл, сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйлангийн хүртээмж, сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх.

5.2.9. Сурлага,урлаг, спортын чиглэлээр улс, олон улс, тив, дэлхийн чанартай уралдаан, тэмцээнд оролцож амжилт гаргасан хүүхдэд дэмжлэг үзүүлэх, урамшуулах.

5.2.10. Цахим тоглоомын газар, интернет төвүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, хүүхдийн бие бялдар, оюун ухаан, сэтгэл зүй, хүмүүжилд нь сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа газар, төвийн үйл ажиллагааг нь зогсоох хүртэл арга хэмжээ авах.

5.2.11. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн төв байгуулах.

5.3. Хүүхдийг сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлж, бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

5.3.1. Хүүхдэд нөлөөлөх аливаа асуудлыг шийдвэрлэх явцад тэдний үзэл бодлыг харгалзан үзэх, үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох хандлагыг эцэг, эх, асран хамгаалагч болон багш, нийгмийн ажилтанд төлөвшүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах.

5.3.2. Эрсдэлт нөхцөлд байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд орон нутгийн болон үндэсний хэмжээнд зохион байгуулагдах хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлэх.

5.3.3. Сургууль, орон нутгийн бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог хангаж тэдний санал, санаачилгыг дэмжих, туршлагыг түгээн дэлгэрүүлэх.

5.3.4. Хүүхдийн болон тэдний төлөөллийн байгууллагын саналыг сонсох, хүүхэд, тэднийг төлөөлөх хууль ёсны талуудын өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэх боломжийг өргөжүүлж шийдвэрлэлтэд хяналт тавих.

5.3.5. Хүүхдийн эрхийн мэдээллийн сан бүрдүүлж, хүүхдэд тулгамдсан асуудлын талаар судалгаа хийж гаргасан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх.

5.3.6. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг нас, хүйс, газар зүйн байршил, нийгэм, эдийн засгийн байдал зэрэг үзүүлэлтээр гаргаж, дүн шинжилгээ хийх, гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх.

5.3.7. Хүүхдийн нийгэм, оюун санаа, ёс суртахуун, биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийг дэмжсэн контентийг дэмжих, хүүхдэд зориулсан мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэх.

5.3.8. НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, түүний нэмэлт протокол, зөвлөмж болон холбогдох хууль тогтоомжийг хүүхдэд ойлгомжтой хэлбэрээр хялбаршуулан хэвлэж түгээх, энэ чиглэлээр сургалт зохион байгуулах.

5.3.9. Хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлэх, түүнд учрах эрсдэл, хор нөлөөнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллага бүрт “Хүүхэд хамгааллын бодлого”-ийг мөрдүүлэх, эцэг эхийн зөвлөл байгуулах.

5.3.10. Эцэг эх, асран хамгаалагч болон багш, сурган хүмүүжүүлэгчдэд хүүхэдтэй ажиллах эв дүй, хүмүүжлийн эерэг арга, хандлагыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах.

5.3.11. Хүүхдийн асрамж, халамжийн болон хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдаж байгаа, дотуур байр, сүм, хийдэд амьдардаг болон үрчлэгдсэн хүүхдийн амьдрах орчинд нөхцөл байдлын үнэлгээ хийх ажлыг тогтмол хугацаанд зохион байгуулах.

5.3.12. Хүүхдийн аюулгүй, халдашгүй байдлыг хангах зорилгоор цэцэрлэг, сургууль, дотуур байр, хүүхэд харах, хөгжүүлэх үйлчилгээ эрхлэгчийн байр, мөрдөн байцаалтын өрөө, саатуулах болон цагдан хорих байранд камерын хяналтын системийг нэвтрүүлж хүүхдэд ээлтэй болгох.

5.3.13. Гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, сэжигтэн, мөрдөн шалгагдаж байгаа, ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, шүүхээр шийтгэгдсэн хүүхдэд хууль зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах.

5.3.14. Гамшгийн үед хүүхдийн эрхийг хамгаалах, тэдэнд тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг хэрэгжүүлэх, сургууль, цэцэрлэг, хүүхдийн байгууллагад гамшгаас хамгаалах дадлага, сургуулилалтыг тогтмолжуулах.

5.3.15. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрт “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг мөрдүүлэх асуудлыг тусгаж хэрэгжүүлэх.

5.3.16. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа сайн дурын ажилтнуудыг дэмжих, урамшуулах.

5.3.17. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн этгээдийн зан үйлийг өөрчлөх сайн дурын болон албадан сургалтыг тогтмол зохион байгуулах.

ЗУРГАА.ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

6.1.1 Хүүхэд бүр гэр бүлдээ эцэг эхийн хайр халамжид эрүүл энх өсч, хүмүүжиж төлөвших боломж бүрдэж, эцэг эх, асран хамгаалагч болон багш сурган хүмүүжүүлэгч, иргэдийн хүүхдэд тавих анхаарал, халамж, үүрэг хариуцлага нэмэгдэнэ.

6.1.2 Хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлсэн, хүүхэд хамгааллын тогтолцоо бүрдсэн хүүхдэд ээлтэй орчин бүрдсэн байна.

6.1.3 Хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн болон хүүхдийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна.

6.1.4 Хүүхдийг сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх хандлага төлөвшиж, сургууль, орон нутгийн түвшинд хүүхдийн оролцоо бодитой хэрэгжих боломж бүрдэнэ.

6.1.5 Нийгмийн хамгааллын бодлогыг хүүхэд, гэр бүлд ээлтэйгээр хэрэгжүүлэх хандлага төлөвшиж, хүүхдийн ядуурал буурсан байна.

6.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөөг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин						Мэдээллийн эх сурвалж	Хамтрах байгууллага
		ОН	Үзүүлэлт	ОН	Үзүүлэлт	ОН	Үзүүлэлт	ОН	Үзүүлэлт		
Сэргийлэх боломжтой өвчлөлөөс шалтгаалсан хүүхдийн эндэгдэл	Нийт эндэгдлийн дотор эзлэх хувь	2017	67.3	2018	53.8	2019	43.04	2020	34.4	Эрүүл мэндийн үзүүлэлт	ЭМГ

Хүүхдийн өсөлтийн хоцрогдол	Түвшин	2017	2017	2018	2019	2020	2020	20.0	Хоол тэжээлийн үндэсний судалгаа	ЭМГ
Боловсролын хамран сургалтын цэвэр жин	СӨБ-ын хамран сургалт ЕБС-ийн хамран сургалт	2017	СӨБ-н 89% тай ба үндсэн бүлэгт 57% хувилбарт сургалтанд 32% Бага боловсрол 98.5%, суурь боловсрол 95%	2018	СӨБ-н хамран сургалт 93% хүрэх ба үндсэн бүлэгт 65% хувилбарт сургалтанд 28%, Бага боловсрол 98.8% суурь боловсролыг 96%-д хүргэнэ.	2019	СӨБ-н хамран сургалт 96% -д хүргэх ба үндсэн бүлэгт 73%, хувилбарт сургалтад 23%, бага боловсролыг 99% суурь боловсролыг 97%-д хүргэнэ	23.0	Боловсролын статистик	БСУГ
Хүүхдийн эрх, хамгааллын зөрчлийн мэдээлэл Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд	тоо Хувь	2017	446 хүүхэд	2018	2%-иар өсгөнө	2019	3%-иар өсгөнө	2020	ГБХЗХГ Хамтарсан багийн мэдээ 108 утасны үйлчилгээнд хандсан тоо	ЦГ, ГБХЗХГ
Нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай гэр бүлд амьдарч буй хүүхэд	Хувь	2017	34.5	2018	34.1%	2019	34%	2020	ҮСХ, ХХҮГ-ын статистик	ХХҮГ
5 хүртэлх насны хүүхдийн осол гэмтлээс шалтгаалсан эндэгдэл	түвшин	2017	11.03	2018	10.0	2019	9.02	2020	Эрүүл мэндийн үзүүлэлт	ЭМГ
Хүүхдэд ээлтэй байгууллага	-Хүүхдэд ээлтэй эмнэлэг, сургууль аж ахуй нэгжийн эзлэх хувь	2017	0	2018	10%	2019	15%	2020	Гэрчилгээ авсан байгууллагын тоо	НБХ, ТЗУХ, ЭМГ, БСУГ, ГБХЗХГ
Хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагдсан хүүхдийн хувь	хувь	2017	60%	2018	65%	2019	70%	2020	Боловсролын статистик	БСУГ, ГБХЗХГ

Бага боловсролын төгсөлтийн бохир жин	хувь	2017	99.5%	2018	99.7%	2019	99.8 %	2020	100%	Боловсролын статистик	БСУГ, ГБХЗХГ
Суурь боловсролын төгсөлтийн бохир жин	хувь	2017	99.7%	2018	99.8%	2019	99.9%	2020	100%	Боловсролын статистик	БСУГ, ГБХЗХГ
Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагад хамрагдаж байгаа хүүхдийн эзлэх хувь	хувь	2017	30 %	2018	5%-иар нэмэгдүүлнэ.	2019	7%-иар нэмэгдүүлнэ.	2020	10%-иар нэмэгдүүлнэ.	ГБХЗХГ-ын мэдээллийн сан	ГБХЗХГ
Хүүхдийн саналыг шийдвэртээ тусгасан нутгийн захиргааны байгууллагын шийдвэрийн хувь	Хувь	2017	8 тогтоол /1.8%/ 56 захирамж /3.08%/	2018	2%-иар нэмэгдүүлнэ	2019	2.5%-иар нэмэгдүүлнэ	2020	3%-иар нэмэгдүүлнэ	ГБХЗХГ-ын мэдээллийн сан	ГБХЗХГ
Хүүхдээс хүлээж авсан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	-Хүүхдээс ирүүлсэн нийт өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь	2017	89%	2018	90%-иас доошгүй	2019	91%-иас доошгүй	2020	92%-иас доошгүй	ГБХЗХГ-ын мэдээллийн сан	ГБХЗХГ
Орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан дахь хүүхдэд ээлтэй үйлчилгээний зардлын эзлэх хувь	хувь	2017	17.0	2018	19.8	2019	25.0	2020	30.0	НҮБХС-ийн захиалгат судалгаа	СТСангийн хэлтэс ХХҮГ
Хүүхэд хамгааллын үйлчилгээнд төсвөөс олгож байгаа санхүүжилт	Улсын төсвөөс олгосон хөрөнгө (сая төгрөгөөр)	2017	7,151,200	2018	21,000,000	2019	3%-иар өссөн	2020	3%-иар өссөн	ГБХЗХГ-ын мэдээллийн сан	СТСангийн хэлтэс, ГБХЗХГ

Сэтгэл зүйн болон бие махбодийн шийтгэл	-сэтгэл зүйн шийтгэл хүлээсэн 1-14 насны хүүхдийн эзлэх хувь -бие махбодийн шийтгэл хүлээсэн 1-14 насны хүүхэд	2017	25 хүүхэд	2018	0.2%-иар бууруулна.	2019	0.3%-иар бууруулна.	2020	0.4%-иар бууруулна.	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа	ГБХЗХГ
---	--	------	-----------	------	---------------------	------	---------------------	------	---------------------	--------------------------------------	--------

ДОЛОО.ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

7.1.1. Улсын болон орон нутгийн төсөв.

7.1.2. Олон улсын байгууллага болон хандивлагч байгууллагын зээл, тусламж.

7.1.3. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламж.

7.1.4. Орон нутгийн хөгжлийг дэмжих сан

7.1.5. Бусад эх үүсвэр

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, удирдлага зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газар, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж буй “Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр”-ийн зохицуулах баг, хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүргийг салбар дундын хамтын ажиллагааг хангасан дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх баг хариуцна.

8.2. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийн хэмжээнд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шаардагдах төсвийг баталж, хэрэгжилтийн дүнг хэлэлцэж, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн идэвх санаачилгыг дэмжиж хамтран ажиллана.

ЕС.ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс хариуцан төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран жил бүр хийнэ.

9.2. Сумдын Засаг дарга хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг ГБХЗХГазарт жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор хүргүүлнэ.

9.3. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээний ажлын зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн шалгуур үзүүлэлт, зорилтыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, туршлага сургамжийг нэгтгэн дүгнэх, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулсан хөрөнгө хүндээ хэрхэн хүрч зохих дэмжлэг болж чадсаныг судалгаа, шинжилгээ, олон нийтийн оролцооны аргаар тогтоон зөвлөмж, санал, дүгнэлт гаргана.

АРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

- 10.1. Хүүхдийн эрхийн тухай конвенц-1989 он;
- 10.2. Хүүхдийн эрхийн тухай хууль- 2016 он;
- 10.3. Хүүхэд хамгааллын тухай хууль-2016 он;
- 10.4. “Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих үндэсний хөтөлбөр”- 2017 он;
- 10.5. Зөрчлийн тухай хууль 6.20 дугаар зүйл, 10.23 дугаар зүйл-2017 он;
- 10.6. Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр 2017-2021 он;
- 10.7. Гэр бүлийн тухай хууль 1999 он;
- 10.8. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2016 он;
- 10.9. Хуульд нийцүүлэн гаргасан Засгийн газар, яам, тусгай газрын журам, тогтоолууд, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Засаг даргын захирамж, бусад шийдвэрүүд;